



**ШИВЭЭ-ОВОО
ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2016 оны 0᠔ сарын 15 өдөр

Дугаар А/1᠒

Сэвхүүл

Төлөвлөгөө батлах тухай


Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйл, Авлигтай тэмцэх газрын даргын 2015 оны А/88 дугаар тушаал, Авлигын эсрэг болон Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль тогтоомжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Компанийн 2016 оны Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг 1 дүгээр хавсралтаар баталж 2016 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдсүгэй.

2.Төлөвлөгөөний хэрэгжилтийг зохион байгуулж, биелэлтийг тогтоосон хугацаанд гаргаж Авлигтай тэмцэх газар, Эрчим хүчний яам, Уул уурхайн яаманд хүргүүлэхийг Захиргаа, хүний нөөцийн бодлогын хэлтсийн Хуулийн зөвлөх/А.Энхгэрэл/-д үүрэг болгосугай.

1 дүгээр хавсралт: 6 хуудастай

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



О.ОТГОНБААТАР



“Шивээ-Овоо” ХК-ийн Гүйцэтгэх захирлын
2016 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн
А/12 дугаар тушаалын дүгээр хавсралт

“ШИВЭЭ-ОВОО” ХК-ИЙН АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 2016 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

| Дэд хэсэг | Хийх ажлын агуулга | Хуулиар хүлээсэн үүргийн биелэлт | | Хүрэх үр дүн | |
|-----------|--|--|---|---|--|
| | | Хийгдэх ажил | Шалгуур | | |
| 1 | <p>Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, энэ талаарх мэдээллийг иргэд, байгууллага чөлөөтэй авах нөхцөлийг хангах</p> <p>Эрх зүйн үндэслэл:</p> <ul style="list-style-type: none"> Авлигын эсрэг хууль 5 дугаар зүйлийн 5.1.2; Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.5; Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2. | <p>Хийгдэх ажил</p> <p>1.1. Хэлтэс хэсэг нэгж дээр байрлах мэдээллийн самбаруудын үйл ажиллагааг тогтмолжуулж, аливаа гарсан тушаал шийдвэр, тэдгээрийн биелэлт зэргийг цаг тухай бүр нийтэлж хэвшүүлэх. Авлигын эсрэг Авилгатай тэмцэх газраас болон компанийн зүгээс хэрэгжүүлж буй үйл ажиллагааг мэдээллийн самбар, цахим хуудсаар дамжуулан ажилчид болон олон нийтэд сурталчлах.</p> <p>1.2. Авлигатай тэмцэх газар, төрийн болон төрийн бус байгууллагаас авлигын эсрэг зохион байгуулж буй аливаа хөтөлбөр мэдээ мэдээлэл, зурагт хуудас, зэргийг сурталчлах зорилгоор авлигын эсрэг үйл ажиллагааны булан, самбартай болох.</p> | Шалгуур | <p>ЗХНБХэлтэс-захиргааны мэргэжилтэн, хэлтэс хэсэг нэгжийн удирдлагууд</p> <p>ЗХНБХэлтэс-Хэвлэл мэдээлэл олон нийттэй харилцах мэргэжилтэн</p> | <p>Авлигын эсрэг үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах, мэдээ мэдээлэл олгох</p> |
| 2 | <p>Шинээр боловсруулж байгаа бодлогын баримт бичгийн шийдвэрийн төслийг олон нийтэд танилцуулах, сонирхогч бүлгүүдтэй харилцан санал солилцох</p> | <p>Хувьцаа</p> <p>2.1. Боловсруулж байгаа Хувьцаа эзэмшигчдийн болон Төлөөлөн удирдах зөвлөл, захирлын зөвлөлийн хурлаар хэлэлцэгдэх бодлогын баримт бичгийн төсөлд иргэд, олон нийт, сонирхогч бүлгийн санал, шүүмжлэлийг хүлээн авч тусгах тогтолцоог боловсронгуй болгох.</p> | <p>ТУЗ-ийн нарийн бичиг, ЗХНБХэлтэс- Захиргааны мэргэжилтэн</p> | <p>Аливаа дээд шатны болоод удирдах албан тушаалтнаас гарч буй шийдвэрт, сонирхогч талуудын оролцоог хангаж тэдний эрх ашиг, сонирхлыг тусгасан</p> | |

| | | | |
|---|--|--|--|
| | <p>Эрх зүйн үндэслэл:</p> <ul style="list-style-type: none"> • Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2; • Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.5 | <p>2.2. Боловсруулж байгаа Хувьцаа эзэмшигчдийн болон Төлөөлөн удирдах зөвлөл, захирлын зөвлөлийн хурлаар хэлэлцэгдэх бодлогын баримт бичгийн төслийг тохиромжтой хүртээмжтэй байдлаар мэдээлж хэвшүүлнэ. /Жич: Цахим хуудас, Сошиал медиа, хурал зөвлөгөөн хийх г.м/</p> | <p>Бодит шийдвэр гаргах боломжийг бүрдүүлэх</p> |
| 3 | <p>Төсвийн орлого, түүний зарцуулалт, гадаадын зээл, тус-ламж, түүний хуваарилалтыг олон нийтэд тухай бүр мэдээлэх /цахим хуудсаараа/</p> <p>Эрх зүйн үндэслэл:</p> <ul style="list-style-type: none"> • Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4; • Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6 дугаар зүйлийн 6.4, 6.8.3 | <p>3.1. Төсөв санхүүгийн ил тод байдлыг хангах, шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах зорилгоор төсөв санхүүгийн орлого, зарлага зарцуулалтыг хариуцаж ажилладаг ажилтнуудын ажлын байрны тодорхойлолт, төсөв санхүүгийн асуудал эрхэлсэн хэлтсийн ажиллах журамд өөрчлөлт оруулах. /Мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангахад чиглэгдсэн үйл ажиллагааг нарийвчлан тусгаж үүрэгжүүлэх./</p> | <p>ЗХНБХэлтэс хүний нөөцийн мэргэжилтэн, хуулийн зөвлөх, СЭЗХэлтсийн дарга</p> <p>Хуулийн хэрэгжилтийг хангахад чиглэсэн үйл ажиллагаа оновчтой болно.</p> |
| 4 | <p>Хүний нөөцийн ил тод байдлыг хангах, олон нийтийг түүнтэй танилцах боломжоор хангах</p> <p>Эрх зүйн үндэслэл:</p> <ul style="list-style-type: none"> • Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.5, 6.1.6; • Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 | <p>4.1. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд, Гүйцэтгэх захирал, Хэлтэс хэсэг нэгжийн удирдлага зэрэг удирдах албан тушаалтнуудын танилцуулга, эрхлэх үйл ажиллагааны талаар цахим хуудсандаа баяжуулан байршуулах, аливаа өөрчлөлт орсон тохиолдолд 7 хоногт багтаан тухай бүр шинэчилж байх.</p> <p>4.2. Хүний нөөцийн ил тод байдлыг хангах, ажилтан сонгон шалгаруулах үе шатыг тодорхой болгох, хөдөлмөрийн зах зээлээс чадвартай боловсон хүчнийг олж ажиллуулах, хүний нөөцийг бүрдүүлэх зорилгоор, ажилтан сонгон шалгаруулах журмыг шинэчлэн боловсруулах.</p> | <p>Иргэд олон нийт, хүний нөөцтэй холбоотой сул орон тоо, ажилтан сонгон шалгаруулалтын талаар мэдээ мэдээллийг цаг тухай бүр авч, байгууллагын хүний нөөц бүрдүүлэлт сайжирна.</p> <p>ЗХНБХэлтсийн дарга, хүний нөөцийн мэргэжилтэн</p> |

| | | | | |
|---|--|--|---|--|
| 5 | <p>Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах, түүнтэй танилцах боломжоор хангах</p> <p>Эрх зүйн үндэслэл:</p> <ul style="list-style-type: none"> • Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4; • Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.3, 6.4.4, 6.4.6; • Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 21 дүгээр зүйл, 47 дугаар зүйлийн 47.4, 48 дугаар зүйлийн 48.5 | <p>5.1. Худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах зорилгоор өөрийн цахим хуудсанд шинэчлэлт хийж “Худалдан авах ажиллагаа” гэсэн дэд цэсийг 3-р сард багтаан боловсронгуй болгож олон нийтэд хамгийн ойлгомжтой хэлбэрээр зохион байгуулалтыг хийх.</p> <p>5.2. Засгийн газрын худалдан авах ажиллагааны цахим хуудас болон өөрийн цахим хуудсанд худалдан авах ажиллагаатай холбоотой мэдээ мэдээллийг тогтмол байршуулж хэвшүүлэх. Холбогдох ажилтнуудын ажлын байрны тодорхойлолт болон эрхлэх үйл ажиллагааны жагсаалтад тусгаж, хариуцлагажуулах.</p> | <p>ЗХНБХэлтэс-Хэвлэл мэдээлэл олон нийттэй харилцах мэргэжилтэн, Худалдаа хангамжийн хэлтсийн дарга</p> <p>Худалдан авах ажиллагаатай холбоотой мэдээ мэдээллийг олон нийтэд хүргэх үйл ажиллагаа сайжирна.</p> | |
| 6 | <p>Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх ёс зүйн дүрмийг тогтоон мөрдүүлэх</p> <p>Эрх зүйн үндэслэл:</p> <ul style="list-style-type: none"> • Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.1, 7.2.2, 7.2.4, 7.2.5, 10-22 дугаар зүйл, 29 дүгээр зүйлийн 29.2; • Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.6, 6.1.9, 6.8. | <p>6.1. Компанийн хэмжээнд мөрдөгдөж буй “Ёс зүйн дүрэм”-ийг танилцуулах, албан тушаалтнуудын ёс зүйн хэм хэмжээнд үнэлэлт дүгнэлт өгөх зорилгоор ажилчидтай жилд 2 буюу түүнээс дээш удаа уулзалт зохион байгуулах, судалгаа авах.</p> <p>6.2. Компанийн “Ёс зүйн дүрэм”-ийг мөрдөж ажиллах талаар сургалт танилцуулга хийх, зөрчил илэрсэн тохиолдолд хуулийн дагуу хариуцлага тооцох.</p> <p>6.3. Компанийн “Ёс зүйн дүрэм”-ийн хэрэгжилтийн талаар хагас бүтэн жилээр ажилчдад мэдээлдэг байх.</p> | <p>“Шивээ Овоо” ХК-ийн Ёс зүйн хороо</p> | <p>Ажилчдын ёс зүйн хэм, хэмжээнд үнэн зөв үнэлэлт дүгнэлт өгч, ёс зүйн хэм хэмжээг сайжруулан хариуцлагажуулах боломжтой болно.</p> |

| | | | | |
|---|--|--|--|--|
| 7 | <p>Байгууллагын удирдлагаас гаргаж буй шийдвэрийн ил тод, нээлттэй байдлыг хангах</p> <p>Эрх зүйн үндэслэл:</p> <ul style="list-style-type: none"> • Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.10; | <p>7.1. Хувьцаа эзэмшигчдийн хурал болон Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоол, Захирлын зөвлөлийн хурлын шийдвэр, Гүйцэтгэх захирлын тушаал, шийдвэрийн талаар ажилчид болон олон нийтэд мэдээлэх зорилгоор компанийн цахим хуудас болон хэлтэс хэсэг нэгжийн мэдээллийн самбарт мэдээлэлж хэвшүүлэх,</p> <p>7.2. Улирал тугам “Уурхайчин” сонин гаргаж бүх ажилчид болоод сум орон нутгийн иргэдэд “Шивээ Овоо” ХК-ийн үйл ажиллагаатай холбоотой цаг үеийн мэдээ мэдээллийг түгээж хэвших</p> | | <p>Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой, аливаа шийдвэр, мэдээ мэдээллийг олон нийтэд нээлттэйгээр мэдээлэх, үнэн зөвөөр цаг тухай бүр нь хүргэх боломжтой болно.</p> |
| 8 | <p>Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, дүрэм, журам, зааврыг цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байршуулах</p> <p>Эрх зүйн үндэслэл:</p> <ul style="list-style-type: none"> • Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.10; • Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.4. | <p>8.1. Компанийн үйл ажиллагааныхаа хүрээнд дагаж мөрдөж байгаа хууль тогтоомж болон эрх зүйн акт дүрэм журмыг цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байршуулах, өөрчлөлт орсон тохиолдолд цаг тухай бүр шинэчлэлт хийж хэвшүүлэх.</p> <p>8.2 Компанийн хэмжээнд дотооддоо дагаж мөрдөхөөр батлан гаргасан дүрэм журмыг иргэд олон нийт, харилцагч байгууллагатай хамаарал бүхий журмуудыг татаж авах болон унших боломжтойгоор, компанийн нууцын журамд заасан дүрэм, журам, бизнесийн үйл ажиллагаатай холбоотой бодлогын баримт бичиг зэргийг нэр томьёоны жагсаалт байдлаар цахим хуудсандаа байршуулж хэвших.</p> | <p style="text-align: center;">ЗХНБХэлтэс-Хуулийн зөвлөх</p> | |

| | | | | |
|----|---|--|--|--|
| 9 | <p>Иргэдийн өргөдөл /санал, мэдэгдэл/, гомдол, хүсэлтийг хүлээн авах, шийдвэрлэх шат дамжлагыг цөөрүүлэх, зөрчлийн талаарх мэдээллийг хүлээн авч шалгах</p> <p>Эрх зүйн үндэслэл:</p> <ul style="list-style-type: none"> • Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.11; • Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.2; • Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.3; | <p>9.1. Албан байгууллага болон иргэд, ажилчдаас ирүүлсэн аливаа хүсэлт, санал, гомдлыг хүлээн авч бүртгэх, шийдвэрлэх, хариу өгөх механизмыг боловсронгуй болгож, журамлах.</p> <p>9.2. Цахим хуудсаар болон, цахим шуудангаар дамжуулан санал гомдол хүлээж авах, хариу өгөх тогтолцоог тодорхой асуудлуудын хүрээнд авах боломжоор хангаж, тогтолцоог бий болгох.</p> <p>9.3 Хүсэлт, санал гомдлын шийдвэрийн талаар цахим хуудсаар дамжуулан сар бүр тогтмол мэдээллийг байршуулж хэвшүүлэх.</p> | <p>ЗХНБХэлтэс</p> | <p>Албан байгууллага болон иргэд ажилчдаас гаргасан санал гомдлыг шийдвэрлэх үе шат багасч, түргэн шуурхай, хариуцлагатай шийдвэрлэх зөв тогтолцоог бий болно.</p> |
| 10 | <p>Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах</p> <p>Эрх зүйн үндэслэл:</p> <ul style="list-style-type: none"> • Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.12; • Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.1 | <p>10.1. Авлигад өртөж болох ажлын байрны судалгааг санал асуулга болон ажлын байрны чиг үүргийнх нь хүрээнд судалгаа хийж жагсаалтыг гаргах. Гаргасан жагсаалтын дагуу холбогдох ажлын байрнууд дээр Авлигын эсрэг хуулийн талаар сургалт зохион байгуулах. Ажлын байрны тодорхойлолт, дотоод зохион байгуулалтыг өөрчлөх замаар гарч болох эрсдэлийг бууруулах арга хэмжээг дотооддоо зохион байгуулах.</p> | <p>ЗХНБХэлтэс – Хүний нөөцийн мэргэжилтэн, хуулийн зөвлөх</p> | <p>Авлига гарч болзошгүй эрсдэлийг бууруулна.</p> |
| 11 | <p>Байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзлэл, хүчин чармайлт</p> | <p>Авлигатай тэмцэх санал, санаачилга</p> <p>11.1. Авлигалын эсрэг хууль болон Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хүрээнд Үйлдвэрчний эвлэл болон Залуучуудын холбоотой хамтран Говьсүмбэр аймгийн Шивээговь сумын 3-р</p> | <p>ЗХНБХэлтэс – Сургалтын менежер, Хэвлэл мэдээлэл олон нийттэй харилцах мэргэжилтэн</p> | <p>Иргэд олон нийт, ажилчдын авлигын тухай мэдлэг мэдээлэл сайжирч, авлига гарч болзошгүй эрсдэл</p> |

| | | | | |
|----|--|---|---|---|
| | | <p>10-н жилийн сургуулийн ахлах, дунд ангийн сурагчдын дунд хөгжөөнт танин мэдэхгүйн "Асуулт хариултын тэмцээн" зохион байгуулах.</p> <p>11.2. Авлигын эсрэг хуулийг сурталчлах, байгаль орчноо хайрлан хамгаалах үзлийг төлөвшүүлэх зорилгоор "Залуучуудын холбоо"-той хамтран Шивээговь сумын нийт албан байгууллага аж ахуй нэгжийн дунд явган аялал зохион байгуулж асуулт хариултын "АХА" тэмцээн зохион байгуулах.</p> <p>11.3 Говьсүмбэр аймгийн Сүмбэр сум, Шивээговь сумын иргэдтэй уулзалт өдөрлөг зохион байгуулж, компанийн үйл ажиллагаатай холбоотой мэдээ мэдээллийг өгөх. Орон нутгийн иргэд болон уурхайн ажилчдаас санал асуулга авах зарчмаар "Компанийн нийгмийн хариуцлагын үйл ажиллагаанд" үнэлэлт дүгнэлт гаргаж, үйл ажиллагааг зөв зохион байгуулах</p> | | буурна. |
| 12 | Албан хаагчдын шударга байдал ба түүнийг нэмэгдүүлэх | <p>12.1. Бүх хэлтэс хэсэг нэгж дээр мэргэжлийн байгууллагатай хамтран ажилчдын ажлын байрны зураг авалтыг хийж, ажлын гүйцэтгэлийн үнэлгээний шалгуур үзүүлэлтийг гаргах. Гаргасан шалгуур үзүүлэлтийг харгалзан шагнал урамшуулал, үр дүнгийн цалин олгох, зэрэг бүхий л хөдөлмөрийн харилцаатай журмыг шинэчлэн боловсруулах.</p> | ЗХНБХ-элтэс- Дарга, Хүний нөөцийн мэргэжилтэн, Хэлтэс хэсэг нэгжийн удирдлагууд | Ажилчдын ажлын үзүүлэлтийг хариуцсан ажлын байрныхаа хүрээнд үнэн бодитой үнэлж дүгнэх, шалгуур үзүүлэлтүүд тодорхой болно. |